



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2006 оны 64 дүгээр тогтоол, “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2013 оны 314 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Архив, албан хэрэг хөтлөлтийн байдалд мэдээллийн технологи нэвтрүүлэх, энэ талаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан асуудлуудыг хэрэгжүүлэх зорилгоор тус газрын үйл ажиллагааны явцад үүссэн архивын баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын хэсгийн үр дүнг 2014 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор Даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Алтансүх/-д даалгасугай.

ДАРГА Ц.ЖАДАМБАА



111333

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2014 оны 04 сарын 16 өдрийн
117 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

ажлын хэсгийн дарга:

Б.Алтансүх Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга

ажлын хэсгийн нарийн бичиг:

М.Нямтуяа Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн

ажлын хэсгийн гишүүд:

Н.Цэвээндарь Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн

З.Болормаа Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн

Б.Болормаа Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн

Б.Сайнтөр Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн

Л.Батбаяр Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн

Э.Хонгорзул Нягтлан бодогч

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2014 оны 44 сарын 16 өдрийн
11.7 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Ажлын хэсгийн удирдамж

УХС 514 5202965

Зорилго:

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны “Үндэсний хөтөлбөр батлах, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 64 дүгээр тогтоол, 2013 оны “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 314 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Тус газрын байгуулагдсан цагаас буюу 2004 оноос хойшхи хугацаанд үүссэн архивын баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлэхдээ Байнга хадгалагдах хадгаламжийн нэгжүүдийг эхний ээлжинд цахим хэлбэрт шилжүүлэх гэсэн зарчмыг удирдлага болгож дараах дарааллын дагуу ажиллах:
 1. Үйл ажиллагааны чиглэлээр гарсан Байнга хадгалагдах тушаал
 2. Боловсон хүчний чиглэлээр гарсан 70 жил хадгалагдах тушаал
 3. Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангууд
 4. Ерөнхий менежерийн он онуудын үр дүнгийн гэрээ, нийлүүлэх бүтээгдэхүүн, гэрээг дүгнэсэн тухай илтгэх хуудас, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлан
 5. Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлүүд
 6. Дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлт
 7. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
 8. Төсөвт байгууллагын бланс, Аудитын дүгнэлт
 9. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайлан
 10. Шалгарсан тендерийн баримтууд
 11. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлангууд
 12. Шаардлагатай бусад байнга хадгалагдах баримтууд
 13. Ирсэн, явсан бичгүүд
- Архивын ерөнхий газраас тодорхой заавар, зөвлөмж авч ажиллах, шаардлагатай тохиолдолд энэ ажлыг нэвтрүүлсэн байгууллагуудын ажилтай танилцах
- Ажлын хэсгийн хүрээнд шаардлагатай төсвийн төслийг тооцоолон удирдлагуудад танилцуулах

Хүрэх үр дүн:

- Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангана.
- Архивын баримтуудын хадгалалт, хамгаалалт сайжирч, архивын ажилтны ажлын ачаалал багасна.
- Архивын баримтуудтай танилцах боломж нээлттэй болж, иргэд мэдээлэл олж авах явц нэмэгдэнэ.

Хугацаа: 2014.04.21 – 2014.05.31